



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 2024

Улаанбаатар хот

Г Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг
шинэчлэн тогтоож, балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 51,849,240.00 (тавин нэгэн сая найман зуун дөчин есөн мянга хоёр зуун дөч) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины ашиглах хугацааг сунгаж, үнийг 30,000,000.00 (гучин сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Нийслэлийн прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга, Ахлах прокурор Б.Ганбаатар, “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Т.Пүрэвхатан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000810
10-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 08 ныгний өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЛЙДВЭРИЙН ГАЗАРТ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашин нэр, төрөл	Үйлдвэрлэгдсэн, ашиглалтад орсон огноо	Арлын дугаар	Улсын дугаар	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)
1	Ниссан теана L33 суудлын автомашин	2016	1N4AL3AP8GC184790	7841 УЖМ	51,849,240.00	5	30,000,000.00
НИЙТ ДҮН							
					51,849,240.00		30,000,000.00 (гучин сая)